

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан
/2017 оны 3 улирлын байдлаар/

2017.09.26

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 тоот захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын дагуу иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэж, хянан шийдвэрлэж байна.

3-р улиралд ирсэн өргөдөл гомдлыг ангилж үзвэл Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс гомдол 3, санал 1, хүсэлт 10 ирснийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүллээ. Үүнд:

1. 2017 оны 07 сарын 03-ны өдөр иргэн З.Галхүүгээс Нисэх, Яармагийн үхэр замаа алдаж байна. АСЕМ-ын үеэр тарьсан моднуудыг идээд дуусч байна. Үүнийг анхааралдаа авна уу гэсэн хүсэлт ирүүлснийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуй газрын мэргэжилтэн Б.Гантулга, Хан-Уул дүүргийн хүнс, худалдаа үйлчилгээний мэргэжилтэн н.Саруултуяа, мэргэжлийн хяналтын улсын байцаагч А.Золзаяа нар 2017 оны 07 дугаар сарын 22-ны өдөр ажиллаж гаднаас гүү барьж байгаа иргэд болон хориглосон бүсийн малчин, мал бүхий иргэдэд албан мэдэгдэх хуудас хүргүүлэн ажиллаж байгаа тухай иргэн Галхүүд утсаар мэдэгдсэн.

2. 2017 оны 07 сарын 03-ны өдөр иргэн Ц.Өнөржаргалаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболдод Малжуулах төсөлд хамрагдаж, Дундговь аймгийн Айраг сумын нутагт мал маллаж, ажиллах хүсэлтэй байгаа тул уг төсөлдөө манай гэр бүлийг хамруулж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч, малжуулах төсөл албан ёсоор хэрэгжиж эхлээгүй байгаа тухай хариуг утсаар мэдэгдсэн.

3. 2017 оны 08 сарын 09-ны өдөр иргэн Г.Амартүвшингээс Найрамдал зуслангийн хавьд малын шүлхий өвчин гарсан. Бүх зам хаагаад оруулахгүй, гаргахгүй болсон. Энд олон айл байгаа. Малтай айл нь цөөхөн малыг нь хөөгөөд олон нийтээс зайтай газар гаргаж болдоггүй юм уу? Энэ газар хоттой ойрхон, хүүхдийн зуслантай газар. Арга хэмжээ авч өгнө үү гэсэн хүсэлт ирүүлснийг хүлээн авч, Хориглосон бүсээс мал амьтныг гаргах, НИТХТэргүүлэгчдийн 85 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын А/592 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Ерөнхий менежер Т.Гантөмөрөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Улаанбаатар хотын Ерөнхий менежер Т.Гантөмөрийн А/126 дугаар тушаалаар 5 дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа талаарх мэдээллийг хүргүүллээ.

4. 2017 оны 08 сарын 02-ны өдөр иргэн Д.Сүхэнхүүгээс СХД-ийн 22 дугаар хороонд манайх зуслангийн газарт гарсан. Малтай айл нь хэтэрсэн байна. 2 айлын хашааны хоорондох зайг бөглөөд олон малтай айл буусан. Тэнд янз бүрийн өвчин тахал гарлаа. СХД-ийн 22 дугаар хорооны нутагт цутгаад хаясан суурь, эзэнгүй зэлүүд газар ихтэй. СХД-ийн газрын алба газрынхаа тухай авч хэлэлцэж байгаа юу? Энэ асуудлаа шийдэж өгнө үү гэсэн өргөдөлтэй танилцаж, иргэн Сүхэнхүүтэй утсаар холбогдож мэдээллийг өглөө. Хориглосон бүсээс мал амьтныг гаргах Нийслэлийн Засаг даргын А/592 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа талаар мэдээллийг хүргүүллээ.

5. 2017 оны 08 сарын 22-ны өдөр иргэн Э.Баясгалангаас Сонгинохайрхан дүүргийн хуучин 22-ын товчоо руу явдаг 2 урсгалтай замын голд их сайхан бургас тарьсан байх юм гэвч зунжин үхэр идээд ургуулахгүй дуусч байна. Тухайн асуудлаар холбогдох газарт нь хэлэхэд нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас "Арга хэмжээ авчихлаа, асуудалгүй" гэж хүн ярьсан. Гэвч ямар ч арга хэмжээ авсан зүйлгүй, яг хэвээрээ байна. Энэ асуудлыг яаралтай шалгаж, шийдвэрлэж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч хэрэгжүүлсэн ажлын талаар иргэн Э.Баясгаланд утсаар мэдэгдсэн.

6. 2017 оны 08 сарын 17-ны өдөр иргэн Туяагаас СБД-ийн 20 дугаар хороо, Сэлхийн зуслангийн засмал зам дагуу үхэр бэлчээд, зам дээр бааж, шээгээд машины дугуйнд наалдаж мөн түгжрэл үүсгэж байна. Арга хэмжээ авч өгнө үү гэсэн гомдол ирснийг хүлээн авч иргэн Туяатай утсаар холбогдож, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/592 тоот захирамжаар нийслэлийн ногоон бүсийн малтай иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж төлөвлөгөө гарган ажиллаж байгаа талаар тодорхой мэдээллийг өгсөн.

7. 2017 оны 08 сарын 23-ны өдөр иргэн С.Адъяабаатараас Нийслэлийн Засаг дарга

бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд танаа: Миний бие БЗД-ийн 28 дугаар хороонд оршин суугч С.Адъяабаатар байна. Энэ өвөл хатуухан өвөл болно. Ялангуяа малын бэлчээр өвс тэжээлийн хувьд. Энэ асуудалд маш их санаа зовж байна. Мал идэж болохоор энэ олон ресторан гуанз цайны газруудаас бас айл өрхүүд гарч байгаа төмс хүнсний ногооны хаягдал хальс иш үндэс бас л малын тэжээл. Цаасан уутанд ялгаж салгаж хийлгүүлээд авчихад болохгүй гэх газар байхгүй. Энэ бодол санааг минь хэрэгжүүлж тус болно уу гэсэн өргөдөлтэй танилцаж иргэн С.Адъяабаатартай утсаар холбогдож "Хог хаягдлын ялган ангилалт хийх тухай" журмын төслийг Захирагчийн ажлын албан дээр боловсруулан ажиллаж байна. Гуанз, цайны газар болон хүнсний захууд ангилалт хийдэггүй болохоор шууд авах боломжгүй байна. Иймд журам боловсруулан гарсны дараа хэрэгжих боломжтой гэдгийг танилцууллаа.

8. 2017 оны 09 сарын 04-ний өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны иргэн Жаргалсайханаас малын шүлхий өвчин гарсан гээд хөл хорио тогтоосон байгаа. Өрхийн хэрэглээ гэж хүн бүрт 20.000 төгрөг өгч байгаа гэх юм. Үүнийг тодруулж өгнө үү гэсэн хүсэлт явуулсныг утсаар холбогдож 20000 төгрөг өгөөгүй гэдгийг өөрт нь хэлж ойлгуулсан болно.

9. 2017 оны 08 сарын 21-ний өдөр ЧД-ийн 19 дүгээр хорооны иргэн Цэцэгдэлгэрээс Манайх Шадивлан 1-200 тоотад оршин суудаг хойноо мод үржүүлгийн газартай. Гэтэл манай энэ хавийн малтай айлуудын мал нь хашаанд орж ирж ногоо сүйтгээд байна. Холбогдох газарт хэлж, иргэдэд нь анхааруулж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч Нийслэлийн Засаг даргын 8 дугаар сарын 2-ны өдрийн 592 тоот захирамжийг танилцуулж холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар танилцуулав.

10. 2017 оны 09 сарын 04-ний өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны иргэн Н.Нармандах Морингийн даваанаас ярьж байна. Хорио цээр хэзээ тавигдах юм бэ. Хүүхэд хуурч байгаа юм шиг нэг үхэр устгаад л 28 хоногийн хорио цээр тогтоогоод байх юм уу. Үүнийг цааш нь дамжуулж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч ХХААХҮЯамны сайдын 2014 оны А/ 93 тоот тушаалаар мал амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зааврын дагуу 28 хоногийн хорио цээр тогтоодог талаар танилцуулсан.

11. 2017 оны 09 сарын 01-ний өдөр Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны иргэн Н.Нармандах үхрийн шүлхий гарсан гээд энд байгаа айлуудыг хорьчихсон, хаашаа ч гаргахгүй байна. Өдөр тутам орлогоо олдог иргэд яаж амьдрах юм бэ? Иргэдийг явуулахгүй хорьчихсон байна. Би машины лизинг төлдөг. Өдөр тутам халтууранд явдаг хүн байна. Би 7 хоног харлаа. Ямар ч шийд байхгүй байна. Хорооны Засаг дарга ирж хурал хийсэн гэж байгаа. Зөвхөн өөрсдийнхөө хүрээний хүмүүстэй хурал хийсэн байна. Иргэдэд юу ч хэлээгүй. Мал байх ёсгүй хотын нэг харьяа дүүрэг шүү дээ. Үүнийг эртнээс зохион байгуулж байхгүй яасан юм бэ? Бид нар юу идэж, яаж ажлаа амжуулах ёстой юм бэ? Гэрээс ч гаргахгүй байна. Үүнийг цааш нь уламжилж өгнө үү гэсэн хүсэлт ирүүлснийг хүлээн авч ХХААХҮ-ийн яамны сайдын 2014 оны А/ 93 тоот тушаалаар мал амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зааврийн дагуу 28 хоногийн хорио цээр тогтоодог талаар танилцуулсан.

12. 2017 оны 09 сарын 01-ний өдөр Хан-уул дүүргийн иргэн Пагмажав хорио цээрийн дэглэмд орсон байгаа өдөр бүр банкинд автомашины лизинг төлдөг орлого байхгүйгээс банкны асуудал үүсээд байна аа энэ асуудлыг яах вэ гэсэн үүний дагуу дүүргийн худалдаа үйлчилгээний хэлтэстэй холбогдож хорио цээрийн дэглэмд байгаа иргэдтэй холбоотой асуудлаар албан тоот хүргүүлэх талаар ханд гэсэн хариуг өгсөн болно.

13. 2017 оны 09 сарын 01-ний өдөр иргэн Ц.Бурмаагаас Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд малын шүлхий өвчин гарсан юм. Манай эмээ бие нь өвдөөд байгаа юм. Очих гэхлээр эндээс гаргахгүй байна. Хоол ундгүй ч боллоо. Сургууль, цэцэрлэгт хүүхдүүдээ явуулмаар байна. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэж, холбогдох газарт нь яаралтай дамжуулж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авч ХХААХҮЯ-ны сайдын 2014 оны А/93 тушаалаар батлагдсан мал амьтны гоц халдварт өвчний үед ажиллах зааврыг танилцуулж уг иргэний ажилладаг байгууллагын нягтланд нь хорио цээрийн дэглэмд орсон тухай утсаар мэдэгдэж уламжилсан болно.

14. 2017 оны 08 сарын 31-ний өдөр иргэн З.Нинагаас Нисэхийн эцсийн буудлаар дүүрэн үхэр бэлчиж байна, үхэртэй айлууд байна. Хажууханд нь малын халдварт өвчин гарсан байна. Хуучин бидний үед хотод малтай айл байдаггүй байсан. Одоо энэ айлуудыг

өөхшүүлээд байлгаад байдаг боллоо. Хөл хорио тогтоовол манайх лав хоригдож чадахгүй шүү. Яаралтай энэ малтай айлуудаа нүүлгээч гэсэн гомдлыг хүлээн авч иргэн Нинад Нийслэлийн Засаг даргын 2017 оны 8 дугаар сарын 02 -ны өдрийн А/592 тоот захирамжаар нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал бүхий иргэдийг гаргах ажлын хэсгийг байгуулж төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа талаар танилцуулсан" бөгөөд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан голомтод байгаа айл өрхийг нүүлгэн шилжүүлэхгүй ахуйн хэрэгцээнд хэрэгцээлэх журамтай байдаг мөн Хан-Уул дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малтай иргэдийн малыг зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлэх ажлыг дүүргийн Засаг даргын тамгын газар, ажлын хэсэг хамтран ажиллаж байгаа бөгөөд Сонгинохайрхан дүүргийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүс рүү нүүлгэхээр газрыг асуудлыг холбогдох газруудтай хамтран шийдвэрлэхээр ажиллаж байгаа талаар утсаар хариу мэдэгдсэн.

15. 2017 оны 09 сарын 08-ны өдөр иргэн Д.Пүрэвсүрэнгээс Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, Сонгинын амралтын баруун талд байдаг сувиллын газар байдаг. Гэтэл морингийн даваанд малын өвчин гарсан гээд зам хаачихсан бид нар нисэхийн урдуур шороон замаар явдаг байсан. Улаанбаатар хотод мал байлгаад дээрээс нь малаа эмчлүүлээгүйгээс болоод бид нар хохирох ёстой юм уу. Үүнийг цааш нь холбогдох газарт нь дамжуулж хэлж өгнө үү гэсэн гомдлыг хүлээн авч иргэн Пүрэвсүрэнтэй хугацаанд нь холбогдож нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр хөл хорио цээрийн дэглэм тогтоодог бөгөөд хорио цээрт орсон тохиолдолд иргэдэд хоол хүнсийг ханган нийлүүлэх ажлыг төр зохион байгуулдаг болохыг мэдэгдэв.

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

/ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 3-ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН/

2017 оны 09 дугаар сарын 25

Нийслэлийн Засаг даргын А/69 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу арга хэмжээг авч ажиллаж байна.

3-дугаар улирлын байдлаар манай байгууллага нийт 50 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, тэдгээр хүмүүст мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2017 оны 07 сарын 20-ны өдөр МБҮ трейд ХХК-ийн захирал Д.Бямбасүрэн газрын дарга Д.Баянбат, захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн, мэргэжилтэн Г.Батбилэг нартай малын худалдааны төвийн газрын гэрчилгээ гаргуулах нэмэлт гэрээний төсөл дээр санал оруулах асуудлаар уулзаж газрын албаны мэргэжилтэнтэй уулзаж газрын гэрчилгээг гаргуулах болж гэрээнд гарын үсэг зурав.

2017 оны 09 сарын 01-ний өдөр иргэн Рэндоо газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэдтэй уулзан газар тариалангийн сургалт хамтарч зохион байгуулах санал тавьсныг ХААШҮОНТөвтэй холбож өгсөн.

2017 оны 09 сарын 12-нд ХУД-ийн 11-р хорооны иргэн М.Цэсмаа газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэдтэй уулзаж жижиг дундын хөтөлбөрт хамрагдах хүсэлт тавьсныг судалж эргэн хариу өгөх болсон.

2017 оны 09 сарын 18-ны өдөр Грийн эльдорадо ХХК-аас газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэдтэй уулзаж намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд оролцох хүсэлт тавьсныг хүлээн авч, үзэсгэлэн худалдааны талаар мэдээлэл өгч хүсэлтийг хүлээн авсан.

Smart-аар 3 иргэн уулзах хүсэлт ирүүлснийг хүлээн авч хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

№	Хэлтэс	Уулзалтын тоо
1	Газрын дарга /Захиргааны хэлтэс/	11
2	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	-
3	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс	18
4	Газар тариалангийн хэлтэс	21
Нийт		50

Иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөлтэй дараах асуудлаар уулзсан.

1.Газрын дарга /4 хэлтэс/

№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	Хамтарч ажиллах саналын талаар	3
2	Ажилд орох хүсэлт	2
3	Цаг үеийн асуудлаар	5
4	Гадаад харилцаа	1
5	Газар тариалангийн чиглэлээр	21
6	Хориглосон бүсээс мал гаргах асуудлаар	18
Нийт		50